



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/95

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Боржигон овогт Чулуунбатын Наранцэцэг /ХО70022808/ нь Шивээговь сумын 1-р баг, 8 дугаар байрны зүүн талд байрлах “Автомашины гараж”-ийн зориулалттай 21 м2 газрын газар эзэмших эрхийг иргэн Цагаанхайрхан овогт Гүрсэдийн Цэвэлмаа /УГ57030301/-д шилжүүлэх хүсэлт гаргасан тул Шивээговь сумын 1-р баг, 8 дугаар байрны зүүн талд байрлах 21м2 газрыг “Автомашины гараж”-ийн зориулалттай газрыг Г.Цэвэлмаад шилжүүлэн өгч 15 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Г.Цэвэлмаа)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Гүрсэдийн Цэвэлмаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/214 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА *Ганчимэг* П.ГАНЧИМЭГ

